



СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№200 /410/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.11.07

Цаг үе, үйл явдал

БРИГАДЫН ГЕНЕРАЛ Г.БОЛОР: ДААРЧ ЗОГССОН СОНСОГЧООС ӨНӨӨДРИЙГ ХҮРТЭЛХ БҮХ ЗҮЙЛ МИНЬ НАМАЙГ БҮТЭЭСЭН

Монголын төдийгүй дэлхийн энхийг сахиулах ажиллагаанд оролцогч эмэгтэй офицеруудын түүхээ, тэдний зориг, хүч, манлайлагч нь монгол бүсгүй байдаг гэхээр уншигч танд эрхгүй бахархал, омогшил төрж байна уу.

Тэр бол Монгол Улсын анхны эмэгтэй Бригадын генерал Ганболдын Болор билээ. Тэрбээр цэргийн сургуулийн анхны зургаан эмэгтэй сонсогчийн нэг, АНУ-ын Нисэх хүчний команд штабын коллежийг төгссөн анхны монгол эмэгтэй офицер, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны төв штабт ажилласан анхны монгол офицер, НҮБ-ийн Өмнөд Судан улсад явагдаж байгаа НҮБ-ийн UNMISS ажиллагааны хүчний штабын холбооны хэлтсийн даргаар ажилласан анхны эмэгтэй билээ.

Гэхдээ тэр хувь хүнийхээ хувьд зөвхөн анхдагч байгаад зогсохгүй энхийг сахиулагч дэлхийн эмэгтэй офицеруудын манлайлал, нийгмийн асуудлуудад Өмнөд Судан Улсад НҮБ-ийн UNMISS ажиллагааны хүчний штабт ажиллаж байх үеэсээ онцгой анхааран тэдний үнэ цэн, үнэлэмжийг илтгэд өсгөн, энхийг дэмжих ажиллагаанд замчилсан гавьяатан билээ. Монгол Улсын Зэвсэгт хүчний нэр хүндийг дэлхийн тавцанд өргөж яваа Монгол Улсын Бригадын генерал Г.Болорыг бид “Блиц” буланд аа урьлаа.

Овог, нэр, төрсөн аймаг,

сум: -Ганболдын Болор, Улаанбаатар хотын хоёрдугаар төрөхөд төрсөн.

Нэгдүгээр ангид аяар үсэг болж байсан бэ?

-Сонирхолтой нь, намайг дуу султай, шүлэг чанга уншиж чадахгүй гээд цагаан толгойн үсэг болгоогүй. Би тэр үед багшдаа их гомдож байсан түүхтэй.(инээв)

Дунд сургуульд байхдаа орж байсан урлагийн арга хэмжээ?

-Би багадаа гитар тоглож сурсан. Тийм болохоор нэгдүгээр ангиасаа эхлээд л урлагийн үзлэгт гитар тоглодог байсан.

Сургуулиа төгсөөд аяар мэргэжил эзэмшинэ гэж мөрөөддөг байсан бэ?

-Эмч болно л гэж мөрөөддөг байлаа.

Миний зөвлөгөө бол “Чин сэтгэлээсээ хүс” л гэж хэлнэ

10 жилийн хамгийн мартагддаггүй, хөгжилтэй дурсамжаасаа хуваалцаач?

-Хоёрдугаар ангийн сурагч байхдаа төрсөн өдрөөрөө ангийнхнаа гэртээ урьсан юм. Тэгсэн хөвгүүд маань надад бэлэг бэлдэхээр бөөндөө яваад бүгд “Өндөр малгайт” гэдэг ном, цаасан цэцэгтэй ирж билээ. 17-18 ширхэг “Өндөр малгайт” гэдэг номтой болж байсан гэсэн үг. Одоо ангийнхантайгаа уулзахаар энэ тухай ярьж инээлддэг юм.

Аяар өнгөнд дуртай вэ?

-Ногоон, хар
Сонсох дуртай дуу?
-Цэргийн дуунуудаа л сайн мэднэ дээ, бүтнээр нь мэддэг өөр дуу бараг байхгүй. Хөнгөн, цоглог аязуудад дуртай юм уу даа.



Байнга уншдаг, унших дуртай номнуудаасаа хуваалцаач?

-Багадаа уран зохиолын ном их уншдаг байлаа. Номын сайн нөхөр I, II, III гээд бүгдийг нь авч байсан, номын сангийн сайн уншигч байв шүү дээ. Одоо бол мэргэжил, сонирхлоо дагаад Манлайлах ур чадварын цувралуудад шимтэж байна.

Англи хэл хэрхэн сурсан бэ. Хэл сурах хамгийн хялбар байж болох зөвлөгөө хэлж өгөөч?

-Манай сургуульд тухайн чиглэлээр суралцах тушаал гарч байж оюутнууд хичээлдээ суудаг юм. Харин надад англи хэл сурах тушаал гараагүй. Гэсэн ч би англи хэл сурахыг үнэхээр хүсэж байсан учраас багшаасаа гуйгаад, ёстой хүслээрээ, туулайчилж сурсан. Хяссан зүйлд хүн илүү хөдөлмөр, сэтгэл, зорилго гаргадаг шүү дээ. Хэрвээ англи хэлний ангид сурах тушаал гарчихсан бол би сайн сурахгүй байсан байж ч мэднэ. Тэгэхээр юуг ч байсан үнэн сэтгэлээсээ хүсэж л байгаа бол заавал амжилт ирдэгт итгэдэг. Миний зөвлөгөө бол “Чин сэтгэлээсээ хүс” л гэж хэлнэ.

Аяар нэг зүйл сурахад хүнд юу хамгийн чухал вэ?

-Хүсэл, зорилго хоёр байхад бүх зүйл болно.

Үлгэр жишээ авдаг эрхэм хүнээ нэрлэвэл, яагаад?

-Олон хүн нэрлэмээр байна. Гэхдээ энэ удаад миний хэлэх хүмүүс бол одоо 20-30 настай манай залуучууд ямар мундаг байна гээч. Дор хаяж 2-3 хэлтэй, амьдралыг үзэх үзэл нь маш өөр, хандлага нь эерэг, аливаад бүтээлч, юманд их өөр өнцгөөс ханддаг гээд хүчтэй, оюунлаг, гэгээлэг, дайчин, ухаалаг залуу үе ирж байгаад би маш их баяртай байгаа. Ийм залуусаас олон зүйл суралцахыг, удаан хамт ажиллахыг хүсэж байна.

Та бол НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны төв штабт ажилласан анхны монгол офицер шүү дээ. Энхийг сахиулах ажиллагааг нэг үгээр илэрхийлбэл?

-Дэнлүү. Энхийг сахиулах ажиллагаа бол үймээн самуунтай байгаа орнуудад зөв, энхийн замыг чиглүүлж, гэрэлтүүлж өгдөг дэнлүү.

Бригадын генерал цол хүртэх болсон тухайгаа сонссон анхны мөчийн сэтгэгдэл?

-Өнөөдрийг хүртэл үзсэн, туулсан, мэдэрсэн, туршлагажсан зам минь зөв зам байжээ. Ээж минь яасан их баярлах бол гэж бодож байсан санагдаж байна. Энхийг сахиулах ажиллагаа бол үймээн самуунтай байгаа орнуудад зөв, энхийн замыг чиглүүлж, гэрэлтүүлж өгдөг

дэнлүү

Их сургуулийнхаа талбайд хөлсөндөө норсон хувцастай оройн тоонд зогсохдоо “Би бусад охид шиг гэртээ байж болох л байсан. Яах гэж энэ мэргэжлийг сонгов оо” гэж бодож байсан тухайгаа та өмнө нь ярьж байсан. Харин монгол улсын анхны эмэгтэй бригадын генерал цолоо аваад зогсож байх үеийн сэтгэгдлээсээ хуваалцаач?

-Даарч зогссон сонсогчоос өнөөдрийг хүртэлх бүх зүйл минь намайг бүтээсэн. Туулсан бүхэндээ хайртай. Цолоо гардаад зогсож байхдаа “Надад өмнөхөөс минь өндөр хариуцлага ирж байна даа. Илүү хичээх, төлөвлөгөөтэй ажиллах хэрэгтэй боллоо” гэж бодсон.

Цол нэмэх, шагнал хүртэх, бусдаасаа түүчээлэх зэрэг бол таны хувьд хийдэг л ажил болсон гэхэд хилсдэхгүй. Хамгийн гол нь амжилт, гавьяа, шагналаа бататгах, түүндээ эзэн байхад ухаан хэрэгтэй байх. Энэ тухайд?

-Хамгийн чухал нь өөрийгөө гээхгүй, хэн байснаа, хаанаас, яаж энд ирснээ мартахгүй байх нь миний зарчим. Зөвхөн цол, гавьяа, шагнал авахаараа ингэж бодоогүй ээ. Байгаагаараа байх нь миний зарчим. “Ганцаараа цойлоод нэг их хол явахгүй” гэдэг үг байдаг шүү дээ.

Очихыг хүсдэг газар?

-Хүүхэд байхын л Касабланкад очиж үзэхийг мөрөөддөг байсан.

Хэрвээ шидтэн танд гурван хүслийг нь биелүүлэх боломж олговол юу хүсэх байсан бэ?

-Хэрвээ шидтэн гэж байгаад, надаас гурван хүсэл асуувал би нэгдүгээрт, ковидыг бүрэн зогсоохыг гуймаар байна. Хоёрдугаарт, хүмүүсийн шуналыг байхгүй болгомоор байна. Тэгш сайхан амьдрах боломж бүгдэд байхад цөөн зарим нь бусдынхаа боломжийг хулгайлж, хүчээр авч байгаатай санал нийлдэггүй. Гуравдугаарт, хүн төрөлхтнийг эрүүл энх, эв найрамдалтай байгаасай гэж хүснэ. Цолоо гардаад зогсож

байхдаа “Надад өмнөхөөс минь өндөр хариуцлага ирж байна даа. Илүү хичээх, төлөвлөгөөтэй ажиллах хэрэгтэй боллоо” гэж бодсон

Аз жаргал таныхаар?

-Жирийн өдрүүдийн хэлхээс л аз жаргал шүү дээ. Үүнийг би энхийг сахиулах ажиллагааны үеэр илүү мэдэрсэн.

Ам бүл хэдүүлээ вэ. Гэр бүлийн хамгийн үнэт зүйл таныхаар?

-Нөхөр, охины хамт гурвуулаа амьдардаг. Манай нөхрийг Д.Хашхүү гэдэг, төрийн их тугч. Гэр бүлийн үнэт зүйл минийхээр бол итгэлцэл. Бүх зүйл дээр бие биедээ итгэж, итгэсэн учраас хамтарч, ойлгож, дэмжиж, хайрладаг гэж боддог.

Аав, ээждээ хэлэхийг хүсдэг үг?

-Аав минь 2015 онд бурхан болсон. Гэхдээ цэлмэг, нартай сайхан тэнгэрийг харахаар аав минь юм шиг санагдаж, биеэ цэхлээд, мөрөө өргөөд “Нэрийг нь хугалахгүй, сайн явахыг хичээж яваа шүү, охин нь” гэж дотроо хэлээд алхдаг. Цэлмэг тэнгэр, дулаахан өдөр аав минь юм шиг санагддаг гэх юм уу даа. Харин ээждээ “Ээж ээ, эрүүл энх байж, бидэнтэйгээ илүү удаан, сайхан амьдраарай” гэж хэлмээр байна. Яг л нөгөө Зүүний сүвэгчээр ч багтах он жилийн урсгалд Зүгээр л дэргэд минь байж хайрла Ижий! гэж дуудах болгондоо баярладаг Ижил хэдэн хүүхдэдээ урт наслаж хайрла аа! гэдэг шүлэг шиг.

Цэлмэг тэнгэр, дулаахан өдөр аав минь юм шиг санагддаг гэх юм уу даа Эх сурвалж:ergelt.mn



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 5	☁️ -8

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 36	☁️ 23

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,415	3,425
EUR 🇪🇺	3,360	3,395
CNY 🇨🇳	464	468
RUB 🇷🇺	52.00	52.50
JPY 🇯🇵	23.00	23.40
KRW 🇰🇷	2.43	2.46

ЗУРХАЙ



2022.11.07 /БААСАН ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 14

НАМРЫН АДАГ ЦАГААН НОХОЙ САР ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ХӨХ ХУЛГАНА ӨДӨР

Үс засуулбал:
Эд мал арвидна
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
07.46-17.26
Барилдлага:
Үл зохилдох
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
Өтлөх үхэхүй

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Эл өдөр андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. /муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/, эд хураах, номын өглөг өгөх, угаах, гадагш эд өгөхөд сайн. Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нь бол элчтэй учрах, хөл тагнай татвал өөрийн гэрт үзэсгэлэн болох, бие татвал бурханыг дурьдахуй болой.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 637,767,096

Эдгэрсэн
Нийт: 617,384,409

Нас барсан
Нийт: 6,605,691

Цаг үе, үйл явдал

БУУДЛАГЫН ДАСГАЛ БОЛОВСРУУЛЛАА



Зэвсэгт хүчний 167 дугаар анги

Цэргийн жинхэнэ албанд 2022 оны II ээлжээр татагдан ирсэн дайчид автоматын анхны дасгал боловсрууллаа.

Тэгвэл I МБР-ын I салааны байлдагч Б.Түвшинтогтох, II салааны байлдагч М.Бямбарачаа, III салааны байлдагч Б.Баянсан,

Э.Гансэлэм II МБР-ын, I салааны байлдагч Б.Эрдэнэжаргал, М.Ангарагмөрөн, II салааны байлдагч Б.Доржрагчаа, А.Билгүүн, О.Очбаяр, III салааны байлдагч Д.Доржсүрэн, Т.Цэрэнням нар бусад нөхдөө манлайлж онц буудагчийн болзол хангасан юм.

Дэслэгч Б.БАТЗАЯА



ХҮРЭЛ МЕДАЛЬ ХҮРТЛЭЭ



Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн Танкийн батальоны хангалт үйлчилгээний салааны захирагчийн орлогч ахлах ахлагч Ц.Батхшиг 2022 оны Мас-рестлингийн Ази

тивийн аварга шалгаруулах тэмцээнд 75 кг жингийн төрөлд эх орноо төлөөлөн оролцож хүрэл медаль хүртлээ.

Ахлах дэслэгч Т.АЛТАНТУУЛ



ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД БУУДЛАГЫН АНХНЫ ДАСГАЛ БОЛОВСРУУЛЛАА



Зэвсэгт хүчний 120 дугаар анги

Ангийн 2022-2023 оны сургалтын төлөвлөгөөний дагуу бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангаж, сэтгэл зүй, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшинг дээшлүүлэх, албад салбаруудын харилцан ажиллагааг хангах зорилгоор энэ сарын 04-ний өдөр тактик, тусгай бэлтгэлийн цогцолбор 15 км-ийн явган маршийг зохион байгууллаа.

Энэхүү маршаар тактикийн ажиллагаа, инженерийн саадыг мөлхөлттэйгөөр туулах, тактикийн болон байр зүйн баримжаалал хийх, хордсон газар орныг туулах ажиллагаа болон офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагч нар гар буу, автоматын нэгдүгээр дасгал, хугацаат цэргийн алба хаагчид буудлагын анхны дасгал боловсрууллаа.

Хошууч Ө.НАРАНТУЯА



БҮЖИГЧИН ХАМТ ОЛОН БОЛНО



Шинэ сургуулийн жил эхэлсэнтэй холбогдуулан Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн хамт олон нэмэлт хөтөлбөрөөр алба хаагчдыг хөгжүүлэх, олон нийтийн ажилд идэвхтэй хамруулах, авьяас, ур чадварыг хөгжүүлэхийн тулд "Бүтээлч хамт олон" гар урлалын бүтээлийн үзэсгэлэнг гаргаж, офицер, ахлагч, ажилтан алба хаагчдын дунд урлагийн үзлэг зохион байгуулах зэрэг

ажлуудыг зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Тэдгээрийн нэг нь бие бүрэлдэхүүнд нийтийн цэнгээнт бүжгийг зааж сургах бүтээлч ажил юм.

Уг сургалтаар бүжгийн боловсролыг олгох, эрүүл аргаар биеийн зохистой харьцааг бүрдүүлэх, бүжгээр дамжуулан гоо зүйн хүмүүжил олгох, эерэг уур амьсгалыг бүрдүүлсний үр дүнд цаашдаа бүжгийн хамт олон болох

зорилгыг дэвшүүлж байна.

Энэхүү сургалтын зохион байгуулах бүжгийн багшаар Ховд аймаг дахь нийтийн цэнгээнт бүжгийн "Мөнгөн давлагаа" клубийн дасгалжуулагч багш МУСТА Намсрайн Банзайдоржийг урьсан юм.

Тэр бээр "Заавал сурах 10 бүжиг"-ийг 11 дүгээр сарын эхний 10 хоногт ангийн байнгын төлөвлөгөөнд заахаар төлөвлөн хэрэгжүүлэн

явуулж байна.

Бүжгийн багш маань одоогоор алба хаагчдад "Гурван тамирын уянга", "Жаахан дулмаа", фокстрот зэрэг бүжгийг сургасан бөгөөд цаашид чардаш, сургуулийн вальс, венгерка буюу цэргийн марш, полька, ёхор, хүмүүн төрөлхтөн, задгай цагаан, румбо зэрэг нийтийн цэнгээнт бүжгийг зааж сургах болно.

Мөн энэ ажлын хүрээнд долоо хоног бүрийн нэг өдрийг "Нийтийн цэнгээнт бүжиг"-ийн өдөр болгон бүжгийн соёлыг залуучуудад түгээн дэлгэрүүлэх, бүжгээр дамжуулан хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэхээр ажиллана.

Мөн сургалтын төгсгөлд шилдэг бүжигчдийг тодруулж шагнаан урамшуулахын зэрэгцээ 2022 оны хоёрдугаар ээлжээр тус ангид татагдан ирсэн хугацаат цэргийн алба хаагчдад нийтийн цэнгээнт бүжгийг зааж сургах юм.


Сэтгэл зүйн хангалтын офицер Д.УЯНГА

СУРГАЛТ

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №18

7 ЭГШГИЙГ УНШИХ, БИЧИХ /үргэлжлэл/

Бид, монгол хэлнийхээ 7 богино эгшгийг монгол бичигт хэрхэн тэмдэглэдгийг "7 титмийн аргачлал"-аар үзэж судалж байгаа билээ. Үгийн төгсгөлд орох гэдэг нь өмнө үзсэн эхэнд, дунд орохоос ялгаатай гэдэг нь илэрхий. Төгсгөлд орох А, Э, И, О, У, Ө, Ү дармалаар:



Бичмэлээр үзүүлбэл:



Эрхэм уншигч та, төгсгөлд ордог А, Э, И, О, У, Ө, Ү гэж аялгуулан дуудаж, бүтсэн зурлагын нь дарааллаар зөв, цэвэрхэн бичиж сураарай.

Үгийн төгсгөлд, А, Э эгшиг адилхан, мөн О, У, Ө, Ү 4 эгшиг адилхан байгаа нь өмнө дурдсанчлан, үгийн хүйс тодорхой болсонтой холбоотой зурлага хэмнэх зарчим юм.

Уруулын эгшгийг төгсгөлд бичихэд гэдсээ үргэлжлүүлэн нум болгодог. Харин А, Э эгшгийг нэг бол сүүл-ээр, эсвэл орхицоор тэмдэглэдэг нь үгийн утга ялгахтай их төлөв холбоотой болой.

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.

* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)